



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/463

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Чандмань хангай” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Цэцэрлэгийн барилгын их засвар /Ховд, Үенч сум/-ын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Нямтулга

- Мэргэжлийн хяналтын газрын
барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Н.Цацрал-цэцэг

- Мэргэжлийн хяналтын газрын
эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар

- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн
салбар сан хариуцсан мэргэжилтэн

Э.Уртнасан

- Үенч сумын Засаг дарга

Т.Тогтохбаяр

- Үенч сумын Цэцэрлэгийн эрхлэгч

Б.Бурмаа

- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Бямбасүрэн

- Барилгын зураг төслийн
“Алтайн газрын хүч” ХХК-ийн захирал

С.Батдорж

- Аймгийн Архивын тасгийн дарга

Б.Оюунгэрэл - “Чандмань хангай” ХХК-ийн захирал
Нарийн бичгийн
дарга: Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилга, хот байгуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. “Чандмань хангай” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН